



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/204

Бат-Өлзий сум

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар үйлийн 32.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын "Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах тухай" 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/615 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс зохион байгуулж ажиллахыг ("Хустын рашаан", "Хутагт уулын өгөөж" Мал эмнэлгийн нэгжүүд) -д үүрэг болгосугай.

2. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг заасан хугацаанд зохион байгуулах, хяналтын баг, вакцинжуулалт хийх ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шүлхийн дархлаажуулалтыг хаврын ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, ажлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын товыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нарт зарлан мэдээлж ажиллахыг (багийн Засаг дарга) нарт үүрэг болгосугай.

4. Малын гоц халдварт шүлхий өвчний халдварлалтыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд вакцины дархлаа тогтоох хүртэл хугацаанд отор нүүдлээр явах, малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг зогсоосугай.

5. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт вакцинжуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2023 оны 10 дугаар
сарын 23-ны өдрийн *А/2023* дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ХЯНАЛТЫН БАГ

Хяналтын багийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
мэргэжилтэн)
П.Аюушжав (Мэл эмнэлгийн тасгийн дарга)

ВАКЦИНЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

1 дүгээр хэсэг (1,2,6 дугаар баг)

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батчулуун (“Хустын рашаан” мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн Малын их эмч)
Гишүүд: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
Б.Батбилэгт (“Хустын рашаан” мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эзэн)

2 дугаар хэсэг (3,4,5 дугаар баг)

Ажлын хэсгийн ахлагч: П.Содномбалжир (“Хутагт уулын өгөөж” ХХК-ны
Малын их эмч)
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
Туслах ажилтан (арван хоёр иргэн)
Хөдөө аж ахуйн тасаг

Бат-Өлзий сумын Засаг даргын
2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
А/2024 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮНэгжүүдийн нэр	Багууд	Хамрагдах малын тоо төрөл	Хамрагдах малын тоо
1.	Хустын Рашаан	1-р баг	Үхэр	9598
		2-р баг	Үхэр	11102
		6-р баг	Үхэр	16588
Бүгд				37288
2.	Хутагт-Уулын-Өгөөж	3-р баг	Үхэр	5969
		4-р баг	Үхэр	9487
		5-р баг	Үхэр	4645
Бүгд				20101
Сумын дүн:				57389

-оОо-

Бат-Өлзий сумын Засаг даргын
2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
1/2024 дүгээр захирамжийн 3 дугаар хавсралт

ШҮЛХИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ажиллах хоног	Удирдах албан тушаалтан	МЭТас аг	Малын эмч		Санитарч, техникч	Туслах ажилтан баригч	Жолооч	Нийт
1	30	4	1	2		2	2	2	13

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ажлын бээлий	ш	75	2000	150000
2	Хурууны лент/нарийн/	Хайрцаг	6	2000	12000
3	Хурууны лент /бүдүүн/	Хайрцаг	6	5000	30000
4	Хагас автомат	ш	5	100000	500000
5	Автомат шприц	ш	1	195000	195000
6	бусад				196000
	Бүгд:				1.083.000

ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Төрөл	Туулах км	Шаардагдах шатахууны хэмжээ /л/	Нэг литрийн үнэ	Нийт мөнгөн дүн
1	1-р баг /машин/	500	100	3900	390000
2	2-р баг /машин/	550	110	3900	429000
3	3-р баг /машин/	150	20	3900	78000
4	4-р баг /машин/	450	60	3900	234000
5	5-р баг /машин/	80	10	3900	39000
6	6-р баг /машин/	800	160	3900	624000
7	Мотоцикл /БЗД нар/	2230	23	2640	60720
8	Нөөц түлш		7	2640	18480
9	Хяналтаар явах /машин/	550	110	3900	429000
	Бүгд	5310	600		2302200

---00---